



GRATA
INTERNATIONAL

**ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН
ТҮНШЛЭЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН
ЗОХИЦУУЛАЛТ**

GRATA International Mongolia

<https://gratanet.com/regions/mongolia>

ТӨР ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ, ТҮҮНИЙ ЗОХИЦУУЛАЛТ

I. Ерөнхий ойлголт

Монгол Улс дахь төр, хувийн хэвшлийн түншлэлийн харилцааг 2010 оны Концессын тухай хуулиар зохицуулж байсан. Тус хуулийг шинэчлэн найруулахаар НҮБ-ын Олон улсын худалдааны эрх зүйн комиссоос 2019 онд баталсан төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай жишиг хууль, түүний гарын авлагыг судалж, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль ("ТХХТХ") –ийн төслийг боловсруулсан бөгөөд Улсын Их Хурлын чуулганы 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн баталсан ба 2023 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөх юм.

Энэхүү хуульд төр, хувийн хэвшлийн түншлэлийн зорилго, хамрах хүрээ, зарчим, нэр томъёо, ойлголтуудыг тодорхой болгож, нийтийн зориулалттай дэд бүтцийн болон төрийн үйлчилгээний чиг үүргийг харилцан үр ашигтай нөхцөлөөр хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх замаар улс орны дэд бүтэц, нийгэм, эдийн засгийн томоохон зорилтуудыг хэрэгжүүлэх эрх зүйн суурь нөхцөл болон төр, хувийн хэвшлийн түншлэлд төрийн байгууллагуудын бүрэн эрх, чиг үүргийг зааг ялгамжтай тодорхойлж, түншлэлийн төслийг хэрэгжүүлэхтэй холбоотой эдгээр байгууллагуудын хоорондын харилцан уялдаа холбоог сайжруулж, санхүү, төсвийн хяналтыг тухай бүр хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрдүүлэхээр тусгасан.

ТХХТХ-ийн үйлчлэх хүрээ

Төр, хувийн хэвшлийн түншлэлийг нийтийн зориулалттай дэд бүтэц, төрийн үйлчилгээний салбарт хэрэгжүүлнэ.

Нийтийн зориулалттай дэд бүтэц гэж нийтэд зориулсан төрийн үйлчилгээний барилга байгууламж, авто зам, төмөр зам, дүүжин зам, газрын доор, дээр байрлах замын байгууламж, бүх төрлийн инженерийн шугам сүлжээ, гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх энгийн болон инженерийн хийц, бүтээц бүхий байгууламжийг ойлгоно.

Харин **төрийн үйлчилгээ** гэж иргэдийн ая тухтай амьдрах таатай орчныг бүрдүүлэх зорилгоор дэд бүтэц, эрчим хүч, зам, тээвэр, эрүүл мэнд, боловсрол, соёл болон холбогдох бусад салбарт төрөөс иргэдэд тэгш, чанартай, үр ашигтай, хууль тогтоомж, стандартын дагуу үзүүлж байгаа олон нийтэд зориулсан үйлчилгээг хэлнэ.

Төр, хувийн хэвшлийн түншлэл батлан хамгаалах, банк, санхүүгийн зах зээлийн бүх төрлийн үйлчилгээ, уул уурхайн салбарын дэд бүтцээр дамжуулан олон нийтэд үйлчилгээ үзүүлэхээс бусад ашиг олох зорилготой ашигт малтмал эрэх, хайх, олборлох, ашиглах үйл ажиллагаанд хамаарахгүй.

II. Түншлэлийн гэрээний төрөл

Хуулийн 15 дугаар зүйлд түншлэлийн гэрээний төрлийг заасан. Тухайлбал,

1. зураг төсөл, төсвийг боловсруулах, барих, ашиглах, шилжүүлэх,
2. барих, ашиглах, шилжүүлэх,
3. барих, шилжүүлэх, ашиглах;
4. барих, түрээслэх, ашиглах, шилжүүлэх;
5. барих, өмчлөх, ашиглах, шилжүүлэх;

6. түрээслэх болон түрээслүүлж төрийн үйлчилгээг үзүүлэх;
7. ашиглалт болон засвар арчлалтыг хэрэгжүүлэх;
8. сэргээн засварлах, эзэмших, ашиглах, шилжүүлэх;
9. удирдлагыг хэрэгжүүлэх... зэрэг нийт 9 төрлийн гэрээг нэр зааж хуульчилсан бөгөөд мөн бүрэн шинжилгээгээр тодорхойлсон бусад төрлүүд байж болохоор хуульд заасан.

Түүнчлэн цаашид “Барих-Шилжүүлэх” төрлийн богино хугацаатай, үр ашиг муутай төслийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэхийг хориглох заалтыг тусгасан болно. Ингэснээр төсвөөс үр ашиггүй концессын төслүүдэд эргэн төлөлт хийдэг байдал арилж, төсвийн ачааллыг бууруулах эрх зүйн орчныг бүрдүүлэх юм.


Түншлэлийн гэрээний хугацааг төслийг хэрэгжүүлэх салбар, төслийн үндсэн шинж болон гэрээний төрлөөс хамаарч талуудын харилцан тохиролцсоноор тогтоох бөгөөд 30 жилээс илүүгүй байна. Талууд Засгийн газрын зөвшөөрлийн үндсэн дээр түншлэлийн гэрээний хугацааг нэг удаа 10 хүртэлх жилээр сунгаж болно.

Түншлэлийн талууд

Төрийн түншлэгчид (a) Монгол Улсын яам, (b) Аймаг, нийслэлийн Засаг дарга, (c) төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээд хамаарах бол **хувийн хэвшлийн түншлэгчид** дээр дурдсан төрийн түншлэгчтэй түншлэлийн гэрээ байгуулж, энэ хуульд заасан түншлэлийн төслийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Компанийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын тухай хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан гадаад, дотоодын хөрөнгө оруулалттай хуулийн этгээд болон хуулийн этгээдийн нэгдэл хамаарна.

III. Түншлэлийн төслийн үе шатууд

Түншлэлийн төсөл нь дараах үе шаттай байна. Үүнд:



Хувийн хэвшлийн түншлэгчийг сонгон шалгаруулах үе шат

Хувийн хэвшлийн түншлэгчийн сонгон шалгаруулалт нь урьдчилсан болон уралдаант гэсэн 2 үе шаттай байна.

Урьдчилсан үе шатанд хувийн хэвшлээс ирүүлсэн төслийн санал сонгон шалгаруулалтын шаардлагыг хангаж байгаа эсэхийг үнэлэх ба шалгуурыг хангасан оролцогчид уралдаант шалгаруулалтад оролцох санал ирүүлэх мэдэгдлийг хураангуй жагсаалт гарснаас хойш ажлын 5 өдөрт багтаан хүргүүлнэ.

Уралдаант үе шатанд түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад сонгон шалгаруулалтын үр дүнгийн талаар мэдээлж, шалгарсан оролцогчтой гэрээ байгуулах зөвшөөрөл авах хүсэлтийг хүргүүлнэ. Гэрээ байгуулах зөвшөөрөл олгогдсон тохиолдолд түншлэгчтэй гэрээ байгуулах санал, дүгнэлтийг Засгийн газраар хэлэлцүүлж,

холбогдох шийдвэрийн дагуу хувийн хэвшлийн түншлэгчтэй гэрээ байгуулах, олон нийтэд мэдээлэх үйл ажиллагааг зохион байгуулна.

Сонгон шалгаруулалтад оролцогчдод дараах үндсэн шаардлага тавигдана:

1. төслийг хэрэгжүүлэх санхүүгийн чадавх, удирдлага, мэргэжлийн хүний нөөц, техник, технологийн чадвар, ажлын туршлагатай байх;
2. Зөвшөөрлийн тухай хуульд заасны дагуу энгийн болон тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх аж ахуйн үйл ажиллагааны хувьд уг зөвшөөрлийг авах шаардлагыг хангасан байх;
3. тухайн хуулийн этгээдийг татан буулгах, дампуурлыг зарлах үйл ажиллагаа эхлээгүй, эд хөрөнгийг нь битүүмжлээгүй, үйл ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зогсоогоогүй байх;
4. сүүлийн 3 жилийн хугацаанд түншлэлийн гэрээг биелүүлээгүй тухай шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр гараагүй байх;
5. хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигч, компанийн эрх бүхий албан тушаалтан нь ял шийтгэлгүй, төрийн түншлэгч этгээдийн удирдах албан тушаалтантай нэгдмэл сонирхолгүй, эсхүл хамаарал бүхий этгээд биш, ашиг сонирхлын зөрчилгүй байх;
6. сонгон шалгаруулалтад оролцогч компанийн эцсийн өмчлөгч болон хараат, охин компани нь харилцан хамааралгүй байх;
7. Татварын ерөнхий хуулийн 27 дугаар зүйлд заасан “харилцан хамааралтай этгээд” биш байх шаардлагатай.

IV. Түншлэгч талуудын чиг үүрэг

Түншлэлд **төрийн түншлэгч нь** дараах нийтлэг чиг үүрэгтэй байна:

1. хувийн хэвшлийн түншлэгчийн үйл ажиллагаанд төслийн хэрэгжилттэй холбоотой хяналт тавих, түншлэлийн гэрээ болон холбогдох хууль тогтоомжийн дагуу аудитын байгууллагыг оролцуулах;
2. түншлэлийн гэрээний хүрээнд шаардлагатай баримт бичгийг гаргуулж авах, тухайн объектод саадгүй нэвтрэх;
3. түншлэлийн төсөл, гэрээ болон хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, хяналт тавих, үнэлэх, дүгнэлт өгөх;
4. дэд бүтцийн байгууламжийг хувийн хэвшлийн түншлэгчид түншлэлийн гэрээний дагуу эзэмшүүлж, ашиглуулах нөхцөлийг бүрдүүлэх;
5. түншлэлийн гэрээнд заасан хугацаа, нөхцөлд үндэслэн түншлэлийн зүйлийн эрхийг хувийн хэвшлийн түншлэгчид олгох;
6. түншлэлийн гэрээнд заасны дагуу төслийн зардлыг төсвөөс санхүүжүүлэх;
7. түншлэлийн гэрээнд заасан тохиолдолд төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай төрөөс үзүүлэх дэмжлэгийн арга хэмжээг хэрэгжүүлэх;
8. түншлэлийн төслөөр үзүүлэх үйлчилгээний чанар, түвшин, тэдгээрийг

<https://gratanet.com/regions/mongolia>

тодорхойлох шалгуур үзүүлэлтийг тогтоох, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, тайлагнах;

9. түншлэлийн гэрээ болон хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг.

Түншлэлд **хувийн хэвшлийн түншлэгч нь** дараах нийтлэг чиг үүрэгтэй байна:

1. түншлэлийн гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэлд суурилсан, чанартай, хүртээмжтэй гүйцэтгэх;
2. түншлэлийн төслийн хөрөнгө оруулалт, санхүүжилтийн эх үүсвэрийг өөрийн хөрөнгө болон санхүүгийн бусад арга хэрэгслээр бүрдүүлэх;
3. үйл ажиллагаа, удирдлагын шилдэг туршлага, инноваци, ноу-хауг тухайн салбартаа нэвтрүүлэх;
4. өөрийн болон түншлэлд оролцогч байгууллагуудын чадавхыг бэхжүүлэх;
5. түншлэлийн гэрээнд заасан нөхцөлийн дагуу түншлэлийн зүйлтэй холбоотой эрхийг хэрэгжүүлэх;
6. түншлэлийн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага төрийн түншлэгч этгээдийг түншлэлийн төслийн үйлчилгээний чанар хүртээмж, санхүүгийн мэдээлэл, энэ хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай тайлан, мэдээллээр хугацаанд нь хангаж, түүний үнэн зөв, найдвартай байдлыг хариуцах;
7. түншлэлийн гэрээ болон хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг.

V. Санхүүжилтийн хэлбэр

Түншлэлийг санхүүжилтийн хэлбэрээс нь хамааран **нэгдүгээрт**, түншлэлийн төслийн зардлыг хэрэглэгчийн төлбөр, хураамж болон төслийн орлогоор санхүүжүүлэх, **хоёрдугаарт**, түншлэлийн төслийн зардлыг түншлэлийн гэрээнд заасны дагуу төсвөөс санхүүжүүлэх, **гуравдугаарт**, дээрх хоёр төрлийн холимог төрлүүдтэй байхаар хуульчилсан.

Төр, хувийн хэвшлийн түншлэл нь түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага буюу Эдийн засгийн хөгжлийн яамны эрхлэх асуудалд хамаарна. Төр, хувийн хэвшлийн төсөв, санхүүгийн удирдлага, хяналт нь Сангийн яамны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах юм.

Засгийн газрын баталгаа

Төслийн бүрэн шинжилгээний үр дүнд үндэслэн түншлэлээр хэрэгжүүлэх төсөлд Засгийн газар дараах баталгааг гаргаж болно:

1. түншлэлийн гэрээ болон түүнийг дагалдан байгуулагдсан гэрээ, тэдгээрийн гол нөхцөл зөрчигдөх нөхцөл үүссэн тохиолдолд түншлэлийн төсөлд төсвөөс

<https://gratanet.com/regions/mongolia>

санхүүжүүлэх үүргийн баталгаа;

2. түншлэлийн төслийг хэрэгжүүлэх явцад бий болсон бараа, ажил, үйлчилгээг худалдан авах, олон нийтийн хэрэгцээнд ашиглах, хэрэглэх баталгаа;
3. төр-хувийн хэвшлийн түншлэлийг хэрэгжүүлэхэд шаардлагатай зээлийн хувьд өрийн баталгаа.

Төрөөс үзүүлэх дэмжлэг

Засгийн газрын шийдвэрээр түншлэлийн гэрээний хүрээнд хувийн хэвшлийн түншлэгчид дараах дэмжлэгийг үзүүлж болно:

1. Газрын тухай хуульд заасны дагуу газар эзэмших, ашиглах эрхээр хангах;
2. төрийн үйлчилгээг үзүүлэх нөхцөлөөр хангах, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг ашиглах эрх олгох;
3. холбогдох хууль тогтоомжид заасны дагуу татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх;
4. түншлэлийн гэрээнд зааснаар төслийн санхүүжилтийн тодорхой хэсгийг төсвөөс санхүүжүүлэх;
5. шаардлагатай тохиолдолд түншлэлийн зүйлийг даатгалд хамруулах;
6. түншлэлийн төслөөр бий болгохоос бусад төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай нийтийн зориулалттай дэд бүтэц, төрийн үйлчилгээгээр хангах;
7. хуульд заасан бусад хэлбэрээр дэмжлэг үзүүлэх.

VI. Түншлэлийн гэрээг дуусгавар болгох

Түншлэлийн гэрээ дараах тохиолдолд дуусгавар болно:

1. түншлэлийн гэрээний хүчинтэй хугацаа дуусгавар болсон бөгөөд талууд сунгах хүсэлт гаргаагүй;
2. түншлэлийн гэрээний нэг тал гэрээний үүргийг зөрчсөн, зөрчлийг арилгах үр дүнтэй арга хэмжээ аваагүй;
3. гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл бий болсон бөгөөд арилгах боломжгүй болсон;
4. хууль болон түншлэлийн гэрээнд өөрөөр заагаагүй бол хувийн хэвшлийн түншлэгч төлбөрийн чадваргүй болсон буюу татан буугдсан;
5. энэ хууль болон түншлэлийн гэрээнд заасны дагуу гэрээг цуцалсан.

Түншлэлийн гэрээг дараах тохиолдолд төрийн түншлэгчийн санаачилгаар цуцална:

1. хувийн хэвшлийн түншлэгч гэрээг ноцтой зөрчсөн, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүй нь гэрээнд зааснаар гэрээг цуцлах үндэслэл болсон;
2. хувийн хэвшлийн түншлэгч татан буугдсаны улмаас түншлэлийн төслийг хэрэгжүүлэх боломжгүй болсон нь нийтийн ашиг сонирхолд хохирол учруулахаар бол түүнээс урьдчилан сэргийлэх, эсхүл түүнийг арилгах зорилгоор;
3. түншлэлийн гэрээг энэ хууль болон бусад хууль тогтоомжийг зөрчиж байгуулсан нь тогтоогдсон бол.

Түншлэлийн гэрээнд дараах тохиолдолд хувийн хэвшлийн түншлэгчийн санаачилгаар гэрээг цуцалж болно:

1. төрийн түншлэгч байгууллагын буруутай үйл ажиллагаанаас шалтгаалж түншлэлийн төслийг түр зогсоосон;
2. төрийн түншлэгч байгууллага хувийн хэвшлийн түншлэгчийн бизнесийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцож, хувийн хэвшлийн түншлэгчийг түншлэлийн гэрээгээр хүлээсэн үүргээ цаашид биелүүлэх боломжгүйд хүргэсэн хууль бус шийдвэр гаргасан, эсхүл хориглосон арга хэмжээ авсан;
3. түншлэлийн төсөл хэрэгжүүлэхэд зориулан хувийн хэвшлийн түншлэгчид эзэмшүүлж, ашиглуулсан газар, бусад хөдлөх болон үл хөдлөх хөрөнгөд гэрээ байгуулахаас өмнө өр төлбөр байсан нь илэрсэн, эсхүл гэрээг байгуулах үед хувийн хэвшлийн түншлэгчид мэдэгдээгүй зөрчил илэрсэн бөгөөд эдгээр нь гэрээг хэвийн үргэлжлүүлэхэд боломжгүй нөхцөл байдал үүсгэсэн бол.

Түншлэлийн гэрээг цуцлахад талуудад олгох нөхөн төлбөрийг хэрхэн тооцохыг гэрээнд заах ба түншлэлийн гэрээний дагуу гүйцэтгэсэн ажлын зохих үнэ цэн, гарсан зардал, тухайн талд учирсан бодит хохирлыг оруулж болно.

VII. Гомдол гаргах, хянан шийдвэрлэх болон маргаан шийдвэрлэх

Хэрэв сонгон шалгаруулалтад оролцогч нь хувийн хэвшлийн түншлэгчийн сонгон шалгаруулалт ТХХТХ болон холбогдох журам зөрчсөн гэж үзсэн бол маргаан хянан шийдвэрлэх зөвлөлд ажлын 5 өдөрт багтаан гомдол гаргах эрхтэй. Маргаан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчийн хүсэлтээр үндэсний болон олон улсын шинжээчийг оролцуулж, дүгнэлт гаргуулж болох бөгөөд холбогдох зардлыг оролцогч хариуцна.

Түншлэлийн гэрээ болон түншлэлийн төсөлтэй холбоотой аливаа маргааныг түншлэгч талууд харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэхийг эрмэлзэх, харилцан зөвшилцөлд хүрч чадаагүй тохиолдолд маргааныг түншлэлийн гэрээнд зааснаар Монгол Улсын шүүх, эсхүл үндэсний болон гадаадын арбитрад хандан шийдвэрлүүлнэ.

<https://gratanet.com/regions/mongolia>

Эх сурвалж:

1. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль (2022)
2. Концессын тухай хууль (2010)
3. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаар төрөөс баримтлах бодлогын баримт бичгийг батлах тухай УИХ-ын 2009 оны 64-р тогтоол
4. Концессын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварын үнэлгээний тайлан (2021)
5. *АХБ-ны Зүүн Азийн газраас нийтлэн гаргадаг техникийн цуврал тайлангууд*: Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийг боловсруулах нь - Олон Улсын туршлагад суурилсан ажиглалт дүгнэлтүүд (2016)

Дэлгэрэнгүй мэдээлэл авах эсвэл асуулт байвал Грата Интернэшнл хуулийн фирмийн Партнер В.Болормаагийн bvolodya@gratanet.com болон Хуульч Т.Буянжаргалын btungalag@gratanet.com хаягаар эсвэл +976 70155031 утсаар холбоо барина уу.

Дэлхийн 20 улсад салбартай олон улсын хуулийн фирм Грата Интернэшнлийн Монгол дах оффис болох Өмгөөллийн "Грата Интернэшнл Монголиа" ХХН энэхүү хууль зүйн мэдээллийг бэлтгэн хүргэв. Энэхүү хуулийн зүйн мэдээлэл нь ерөнхий мэдээлэл өгөх зорилготой бөгөөд тодорхой асуудалд нарийвчлан дүн шинжилгээ хийгээгүй болно. Иймд уншигч нь ямар нэгэн үйлдэл хийх/эс хийхээс өмнө өөрсдийн нөхцөл байдалд тохирсон мэргэжлийн зөвлөгөө авах хэрэгтэй. Энэхүү хууль зүйн мэдээллийг ашигласны улмаас үүссэн аливаа үр дагавар, хохирлыг бид хариуцахгүй.